



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 259

Улаанбаатар
хот

Концессын гэрээ байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Концессын тухай хуулийн 6.1.2, 19.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх “хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээг Монгол, Японы хамтарсан хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан)-т зөвшөөрсүгэй.

2. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргалд нарт тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ